

БОДЬ МӨРИЙН ЗЭРЭГ БА ХҮНИЙ АМЬДРАЛЫН ТОЙРОГ

О.Чимэг, МУИС, НШУС.Шашин судлалын тэнхим. Доктор.

Түлхүүр үг: амьдралын философи, сансрын ба номын хүрд, зан үйл, нийгэмшүүлэх, гурван үүдний мөргөл

1. Амьдралын философи

Мөрийн зэргийн зохиолууд, тэр дундаа Зонхавын "Бодь мөрийн зэрэг нь" хүний амьдрах зам мөрийг зааж, нийгэмших үйл явцад зориулагдсан практик ач холбогдолтой.

Хүний амьдралын зам мөрийг зааж төлөвшүүлэх нь хөгжингүй шашин бүрийн зорилго болдог. Ийм төрлийн сургаалууд ялангуяа Ази, дорнын улс орнуудад философи сэтгэлгээнийх нь салшгүй бүрэлдэхүүн хэсэг болж хөгжиж иржээ. Европын философийн хувьд бол эртний Грек, Ромын үед эдгээр асуудлуудыг ёс зүйн сургаалуудын хүрээнд голлон авч үзэж байснаа христос шашин дэлгэрч цэцэглэхийн хамтаар "хийсвэр" сэтгэлгээ талдаа илүүтэй хөгжих болсон гэмээр байдаг. Харин 19, 20-р зууны үед нэлээд дэлгэрсэн "амьдралын философи" гэх чиглэлүүдэд дээрхи асуудлууд шашныхаа "гадна" тавигдах болсон хэдий ч үзэл санаатай нь ямар нэг хэмжээнд холбоотой байдаг.

Дээрх төрлийн сургаалуудын нийтлэг талаяж амьдарвал зохистүй вэ? Юуг сайн, юуг муу гэх вэ? Ямар хүнийг сайн, ямар хүнийг муу гэх вэ? зэрэг ёс суртахууны асуудлыг авч үздэгт оршдог. Хувь хүнтэй холбоотой дээрх асуудлууд түүний амьдрах өвөрмөц орчин болсон нийгмийн философийн асуудал болж аяндаа тавигдаж болж байжээ..

Амьдралын философийн гол онцлог бол зохистой амьдрал, зөв буруугийн тухай үнэлгээ нь онолын гаргалгааны үр дүнд хүрсэн дүгнэлт бус, харин амьдралын туршлагаас гарч ирсэн байр суурь болж байдгаараа онцлог талтай. Философи дахь хийсвэр сэтгэлгээ нилээд хэсэгтээ энэ туршлагыг нэгтгэн дүгнэх хэрэглүүр болж иржээ. Хуримтлуулсан туршлагыг өвлүүлэх замаар хэрэгждэг нийгэмших үйл явцад энэ туршлагын талаархи ухаарлын илэрхийлэл болж байдаг шашин философийн сургаалууд чухал үүрэг гүйцэтгэдэг. Аливаа амьдрал орчинтойгоо харьцах үндсэн дээр оршин тогтнодог. Тиймээс амьдралын туршлага бол орчиндоо зорьсон үйл ажиллагааны ухаарал байх бөгөөд шашны сургаал номлолууд зөв амьдралын тухай номлохдоо хувь хүний амьдралын тухай төсөөллөө орчинтой нь холбон авч үзсэн байдаг.

2. Сансрын хүрд.

Сансрын хүрдийг бүрдүүлэгч шүтэн барилдлагын 12 гишүүн хорвоогийн амьдралын тухай бурханы шашны үзэл санааг илтгэн харуулдаг.

Сансрын хүрдийг бүрдүүлэгч 12 гишүүн нь :

1/Мунхагийн харанхуй /үйлийн шалтгааныг үл мэдэх/

- 2/Хуран үйлдэхүй /буянт ба нүгэлт үйл/
- 3/Тийн мэдэхүй /төрөл авах ёсоо мэдэх/
- 4/Нэрдүрс / нэр, биеийг олох/
- 5/6 төрөн түгэхүй /биеийн мөн чанарыголох/
- 6/Хүрэлцэхүй /язгуурын шүтэн барилдахуй/
- 7/ Сэрэхүй /мэдрэхүйн шүтэн барилдахуй/
- 8/ Хурьцал /хүсэл, тачаалаа хангах/
- 9/ Төрөл авах /чухал авахуйн цогц/
- 10/Хорвоо /амьдрал/
- 11/Төрөхүй /үр мэндлэх/
- 12/Өтлөх, үхэх эдгээр болно.

Хүрдийн талаар ажиглаж болох зүйл гэвэл түүнд эцэс төгсгөл үгүй ба цэг бүр нь бусад цэгийн замыг давтан эргэлдэж байдаг явдал юм. Өөр нэг ажиглаж болох зүйл гэвэл энэхүүхүрд нь төв цэгийг тойрч эргэлдэнэ. 12 гишүүний хувьд бол өөрийгөө мэдэж, нэр дүрс олохоос авахуулаад орчиндоо шунан татагдах буюу өөр үгээр илэрхийлбэл "орчиндоо зорьсон үйл ажиллагааг " илтгэн харуулах бөгөөд угтаа орчлонгийн үндэс хэмээн буддын философид үздэг минийхлэн барих үзлээр тодорхойлогддог гэж үзэж болно. Хүрдийн онцлогтой холбогдуулан номын хүрд эргүүлэх тухай ойлголтыг санаандаа буулгахад сансрын хүрд нь голлох цэг болсон бурханы номыг тойрч эргэлдэх тухай төсөөлөлгарчирж байгаа юм.

3/ Номын хүрд.

Номын хүрд эргүүлсэн гэж Бурхан багшийн тухай ярьдаг. Үүнийг нь эргэдгээрээ эргэж буй хорвоогийн амьдрал, сансрын хүрд бурханы номын голлох цэгийг тойрч эргэлдэх болсноор төсөөлж болох юм. Бурханы номын хүрд эргэснээр юу өөрчлөгдөх вэ?Бурхан нь бодь модны дор гэгээрснийхээ дараа сургаалаа номлосон нь түүний туршлагын үр дүн байсан. Түүнээс эш авсан бурханы шашинд "туулсан бурхан гэээн ойлголт байдаг нь туршлагаа ухаарч гэгээрснийг нь илэрхийлнэ. Түүний туршлагаас гарсан шинэ баримжаа бурханы шашныг бий болгож зохистой амьдралын тухай тулгуур ойлголтуудыг бүрдүүлж 2 мянга гаруй жил болж байна.

Туулсан бурханы тухай ярихад "туулсан бурхан бодь сэтгэлээс" гэдэг. Зонхавын "Бодь мөрийн зэрэгт" бодь сэтгэлийг "увдисны гол" гэж нэрлэсэн бхйдаг. Энэ нь бурханы туршлага, түүний танин мэдэхүй бусдын тулд зориулагдсан тухай санааг агуулж, хорвоогийн зовлонг нимгэлэх зориулалттай байв.

Буддын философид минийхлэн барих үзлийг зовлонгийн шалтгаан хэмээн үзэж, би үгүйн хоосон чанарын үзэл санааг түүнээс ангижруулах арга зам хэмээн үздэг. Бурхан болоход арга нь бодь сэтгэл бол билиг нь хоосон чанарын үзэл санаа болох тухай "Бодь мөрийн зэрэг"-т дэлгэрэнгүй номлосон байдаг. Бодь сэтгэл гэдгийг хүний сэтгэлийг бүрэн таньж мэдсэн сэтгэл гэж товчоор хэлж болох байх. Бусдын сэтгэлийг таньж мэдэхэд ч өөрийн сэтгэлээр дамжуулан таньж мэдэхээс өөр аргагүй. Нөгөө талаар ертөнцийг танин мэднэ гэдэг хүний ертөнцийг танин мэдэх явдал байдаг утгаараа мөн л хүний сэтгэлийг танин мэдэхүй мөн ажгуу.

"Бодь мөрийн зэрэг"-т "өөрийн сэтгэлийг шинжилвээс бүхэн ном өөрийн сэтгэл дор оршиму" гэсэн үгийг "Билиг барамидын удвис "-наас эш татан хэлсэн байдаг нь тэнцэлгүй зонгийн үед холбогдох бөгөөд хүний мөн чанар, хүний ертөнцийн мөн чанарыг танин мэдэх тухай ойлголт. "Туулсан бурхан бодь сэтгэлээс " бол бурханыг сансрын хүрдийн гадна бус хүрдийн гол төвд байгаагаар төсөөлж болох мэт. Номын хүрд эргүүлсэн үзэл санаанд ертөнцийн тусыг бүтээж чаддаг бодьсатваагийн тухай үзэл ойлголт гол байр суурь эзэлдэг учир номын хүрдийн гол төв бол бодь сэтгэлээс төрсөн туулсан бурхад ба

сансрын хүрд нь тэдний номыг тойрч эргэлдэх болсон тухай санаа гэмээр. Томоохон шашнууд, үүний дотор бурханы шашны сургаал номлол нийгмийн философи, ёс суртахууны чиг баримжаа болсоор ирсэн бөгөөд зовлонгоос ангижрах зөв зам мөрийн төв цэг болж ирсэн билээ. Тэр танин мэдэхүйг "Бодь мөрийн зэрэг"-т бурханыг шүтэн дагахаас эхлэн бурхан болох хүртэлх замаар илэрхийлсэн байдаг. Энэ зорилгод хүрэх хувь хүн ба нийгмийн зам мөрийг дэс дараагаар заасныг дараах байдлаар томъёолж болох юм:

1/Чухаг дээд гуравт итгэж, амьдралын чиг баримжаагаа олох.

2/ Багштай болж, сонирхсон зүйлээрээ явах амьдралын сонголт хийх.

3/Эзэмшсэн мэдлэг туршлагаа эргээд уламжлуулах.

Чухаг дээд гурвын тухайд гадаад, дотоод, далд гэсэн 3 утгаар илрэх тухай судлаач М.Гюнтерийн бичсэнээр өгүүлбэл:

1/ Бурхан гэдэг бол дүр /гадаад утгаараа/ амьдралын хэв маяг /дотоод утгаараа/

2/Ном гэдэг бол их хөлгөний судрууд /гадаад утгаараа/ нирвааны туршлага ба тайвшрал /дотоод утгаараа/

3/Хувраг гэдэг бол гэгээрэх гэж зүтгэж буй хүмүүс /гадаад утгаараа/

Номонд сайн болсон бодьсатва нар /дотоод утгаараа/

Харин далд утгаар бол бурхан болох явдал нь амьдралын суурь, мөр зорилго болох утгаараа цорын ганц аврал.

Хувиран өөрчлөгдөх хүний ертөнцийн төв хүний өөрийн нь сэтгэл. Тэр сэтгэлдээ бурханы дүрийг амьдралынхаа хэв маягаа болгож, амгаланг олж амьдрах нь бурханы шашинтны зорилго. Үүний тулд гагцхүү өөрийгөө гэсэн минийхлэн барих үзэл, хувийн явцуу ашиг сонирхолдоо хязгаар тавьж, бусдын ашиг сонирхолтой уялдуулж амьдрах нь тэдний зам мөрийн чиг баримжаа.

Энэ зам мөрийг бүхэлд нь номлосон Зонхавын "Бодь мөрийн зэрэг" зохиол нь хүний санаа бодол төдийгүй үйл хөдлөл, хэл яриаг цогцоор нь авч үзэж бурханы шашны сургаалаар нийгэмших нийт хүнд зориулагджээ.

XX зууны эхэн үеийн европын буддын судлалд Зонхавын үйл ажиллагааг "шинэчлэл" хэмээн нэрлэхдээ зан үйлийн тухай нэлээд дурдаж байсныг дашрамд дурдая.

Харин зан үйл бол үзэл хэвшүүлэх, нийгэмшүүлэх чухал хэрэглүүр ба хүний амьдралын салшгүй тал гэдгийг түүх харуулдаг бөгөөд бурханы шашинд ч зан үйл энэ хувьдаа нэлээд үүрэг гүйцэтгэж иржээ.

4. Шашны зан үйл.

Буддын шашинд хүнийг бие, хэл, сэтгэлийн цогц гэж үзэн эдгээр гурван үүдний нүглийг боож, буянтай барилдуулахыг зорьдог. Ерөөс хүний санаа бодол, итгэл бишрэл түүний үйл хөдлөл, хэл яриагаар илэрч байдаг бөгөөд аль ч шашны бүрэлдэхүүн хэсэг болдог зан үйл мөн л итгэл бишрэлийнх нь илэрхийлэл болж байдаг. Өргөн утгаар бол нийгмийн бүхий л ёс заншлыг хэвшсэн үзэл ойлголтынх нь илэрхийлэл гэж үзэж болно. Нөгөө талаар шашны зан үйлд оролцох явдал сүсэг бишрэлийнх нь илэрхийлэл болохын зэрэгцээ зан үйлийг үйлдэх замаар сүсэг бишрэл нь хэвшин бэхждэг учраас шашны зан үйл өөрөө эргээд санаа бодлыг төлөвшүүлэх нэг хүчин зүйл мөн гэж үзэж болно.

Хүн даган дуурайн нийгэмшиж энэ үйл явцад ойлголт ухагдахуунаас гадна хүмүүсийн үйл хөдлөл, зан үйл чухал үүрэг гүйцэтгэх төдийгүй зан үйл бол туршлагын нүдэнд харагдахуйц биежсэн илэрхийлэл гэж үзэж болох юм.

5. Гурван үүдний мөргөл.

Гурван үүдний мөргөл нь шүтэн биширсэн сэтгэлийн илэрхийлэл юм. Үүнд биеийн мөргөл нь шүтээнийхээ сайн сайханд сөгдөн биширч буйг, хэлний мөргөл нь түүний сайн сайхныг хэлээр эгшиглүүлэн магтан дуулахыг, сэтгэлийн мөргөл нь сүслэн дагахыг илэрхийлдэг.

Мөргөл нь буяныг хурааж, түйтгэрийг судлах үе гишүүн долоод ордог бөгөөд түүнийг бие, хэл, сэтгэл гэсэн гурван үүдэн боолтын мөргөл гэж ялгадаг. Утгыг тодруулбаас "ариун болох" явдал бөгөөд "ертөнцийн орон зүг нэжгээд хийгээд цаг нэжгээдийн бурхан бус, арван зүг хийгээд гурван цагт оршихуй бурхан бүгдэд зорьсоноос" /1,22a/ биширч мөргөлийг эрэх явдал юм. Үүнд гурван үүдэн тус тусын мөргөлд биеийн мөргөлийн утга нь "сайн явдал" бөгөөд бурхан хамаг бүгд сэтгэлд илт байгаа мэт зорьж, "өөрийн биеийг хумхийн тоос луга тоо адилд хувилгаж "мөргөлийг эрэх явдал бөгөөд энэ нь сайн явдалд сүсэглэх хүчийг төрүүлдэг бол сэтгэлийн мөргөл нь мөн хумхийн тоос нэжгээд нэжгээдийн дээрээс тоос хамаг бүгдтэй адил тооны бурхан бодьсатва номлолын голд заларч, тэдний эрдмийг даган дурдахын сүсэг төрүүлэх явдал, харин хэлний мөргөл нь тэдгээрийг "сайшаах" явдал бөгөөд бие нэжгээд нэжгээдэд толгой тоолошгүй хийгээд толгой нэжгээдэд хэл тоолошгүй хувилж яруу эгшгээр буюу магтаалыг өгүүлэхийг хэлдэг байна. /1,22a/

Ийнхүү гурван үүдний мөргөл нь бурхан, бодьсатва нарыг дээдлэх ба тэдний эрдмийг даган дурдах, "сайн явдалд" сүсэглэх хүчийг төлөвшүүлэх үүрэгтэй байжээ.

1. а/Лувсандагва /Зонхав/ Гурван төрөлхтний анхааран авах бодь мөрийн зэрэг оршвой. /Төвд хэл дээр/. Цаасны хэмжээ 49,5 х 9,5. Барын хэмжээ 27 х6. Мөрийн тоо 223 /Эшлэлийг энэ номоор заав/
б/ Лувсандагва /Зонхав/. Бага бодь мөрийн зэрэг оршив. Төвдийн Молом равжамба хийгээд Монголын гүүш Наганзуна Жүдва аягаа тэхимлиг нарын монгол орчуулгаас хийсэн гар бичмэл./эшлэлүүдэд энэ орчуулгыг голлон тулгуурлав/.
 2. Guenter H. V. SGam.po.pa. Jewel Ornament of Liberation. London, 1959
 3. Чимэг О. Зонхавын "Бодь мөрийн зэрэг дэх нийгмийн философийн үзэл санаа Докторын /Ph.D/. зэрэг горилсон диссертац.МУИС, УБ., 2001
- Chimeg O.
Department of Religion Studies, School of Social Sciences, NUM
Stages on the Path to Bodhi.

Summary

2. Philosophy of life.

Works on Path stages are first of all destined for practice. This kind of teaching is especially peculiarity of Eastern religious and philosophical thought. As for European philosophy, there are directions of "Philosophy of life". Common tendency of all these teachings consists in considering of moral problems of right life, of what is good and what is evil. These problems of personality are always connected with his surroundings and in most cases were set as a social philosophy.

2.A Wheel of life/12 links/

The main peculiarity of philosophy of life consists in basing on personal life experience, which is experience of activities towards surroundings. So ideas on surroundings are also a part of a concept about life. In Buddhism there are the twelve links, representing the wheel of life.

3.Turning a Wheel of Dharma by Buddha.

There is also a concept of turning a wheel of Dharma by Buddha. If we make an observation about peculiarities of rotating wheel, we can see that the wheel has no end and all points of it are repeated by others.

As for the twelve links, its can be defined by attachment to views on I, Soul, Mine. Concerning the wheel of Dharma, we can say that after the turning of it by the Buddha a wheel of life began to rotate around the Buddha's Dharma. There is a term "an experienced Buddha" in Buddhist sutras and it is said that experienced Buddha "results from Bodhi". It means that the Buddha's teaching is the result of his life experience, which was dedicated to other beings. If a method of becoming Buddha is Bodhi, awareness of it is represented by views on emptiness of I, Soul and Mine. Becoming the Buddha means awareness of human mind through awareness of his own one.

4. Socialization through rotating around Buddha's teaching

As for the wheel of life, the Buddha is not outside of the wheel, but in the centre of it, and after the turning of the wheel of Dharma, the wheel of life is rotating around him, and human beings, rotating on the wheel, are guided by him in their morality.

Tsonkapa's Lamrim, reflecting the path to Enlightenment and to becoming Buddha as a whole, considers not only inner world of humans on this path, but also his deeds and speech and is dedicated to their socialization with the help of the Buddha's teaching.

5. Buddhist cult as one of the methods to socialize human beings through the Buddha's teaching.

Buddhist cult is mainly associated with Tsonkapa's modernization and sometimes is considered as moving away from early Buddhism. But it seems that Buddhist cult represents one of the methods to socialize, to shape inner world of humans.

6. Bow by 3 doors/body, speech and mind/

As an example, we can say some words about bow by body, speech and mind, as it is represented in the Stages on the Path to Bodhi " by Tsonkapa /1,22a/. Purpose of bow by body is becoming sublime and means aiming to all Buddhas. Meaning of bow by body is "good deeds" and is giving force to acquire faith in good deeds. Bow by mind is giving force to mention awareness of buddhas and bodhisattvas. Bow by speech is praising them.

Quoted works.

1. Tsonkapa. Stages on the Path to Bodhi for Three kinds of personalities. /in Tibetan/ Size of pages 49,5 x 9,5. Size of xylograph 27 x 6. Number of lines 5. Number of sheets 223.
2. Guenter H.V. SGam.po.pa. Jewel Ornament of Liberation. London, 1959.
3. Chimeg O. Socio-philosophical Ideas in the 'Grades on the Path to Bodhi ' by Tsonkapa. Dissertation work for the degree of Dr of Philosophy /Ph/. NUM, Ulaanbaatar, 2001